

ВАЛЮТЫН ДАЙН

Д.Тунгалаг¹

Их гүрнүүд өөрсдийн эрх ашгийг илүүд үзэж, түүндээ тохирсон валютын бодлого хэрэгжүүлж байна. Гэвч тэдний бодлого хоорондоо зөрчилдөж байгаагаас олон улсад “валютын дайн” хэмээх ойлголт бий болж, цаашлаад энэ нь улам даамжрах вий гэх болгоомжлол газар авлаа. “Валютын дайн”-ы галыг дэвэргэн өдөөхгүйгээр асуудлыг шийдвэрлэх нь их гүрнүүдийн хувьд хийх ёстой чухал ажил болоод байгааг эдийн засагчид нэгэн дуугаар батлах болсон. Эл асуудлаар тэргүүлэгч гүрнүүд санал солилцсоор байна.

Өмнөд Солонгосын Гуанжу хотноо өнгөрсөн оны 10 дугаар сард болсон Их 20-ийн дээд хэмжээний уулзалтын үеэр улс орнууд валютын ханшаа унагах замаар бодлогоо тодорхойлж байгаа нь “валютын дайн” өдөөж байна гээд эл асуудлыг шийдвэрлэхийн тулд харилцан буулт хийхээр тохиролцоонд хүрлээ гэсэн агуулгатай зүйлийг онцолжээ. Энэ үеэр АНУ-ын тал Хятадад дахин анхааруулга өгсөн байна. Тус улсын Сангийн сайд Тимоти Гайтнер Их 20-ийн орнууд 2015 он гэхэд гадаад худалдааны алдагдал, илүүдлээ дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувьтай тэнцэх хэмжээнд хүртэл бууруулах тухай санал тавьсан аж. Энэ нь цаад утгаараа Хятад, Герман зэрэг экспортод түшиглэсэн орнуудаас дотоодын хэрэглээгээ нэмэгдүүлэх хэрэгтэй хэмээн шаардаж байгаатай адил юм. Түүнчлэн юаний ам.доллартай харьцах ханшийг чөлөөлж, зах зээлийн бодит үнэлгээнд нь аваачихыг хүсч байна гэсэн үг юм. Хэдийгээр уг санал нь бүрэн дэмжлэг авч чадаагүй боловч олон улсын валют арилжаанд хүчээр нөлөөлөх нь дэлхийн эдийн засгийн тогтвортой байдлыг нь алдагдуулж байгаа гэдэг дээр төлөөлөгчид бүгд санал нийлж байсан байна. Хөгжиж буй орнууд валютын ханшаа сулруулах бодлого баримтлах болсныг АНУ эрс шүүмжилсэн байна.

АНУ-ын Хятадыг шүүмжилсэн саналыг Их Британи дэмжсэн бол Герман, Хятад эсрэгээр хүчтэй шүүмжилсэн байна. Т.Гайтнерийн “4 хувийн санаачилга”-ыг ОХУ, Итали зэрэг орон хүчтэй эсэргүүцжээ.

Өнөөдөр үүсээд буй валютын дайны эх үүсвэрийг 2008 онд Хятад тавьсан гэхэд болно. Тус улсын бодлого боловсруулагчид юанийг америк доллараас уяхаар болсон. Үүний дүнд Хятадын Ардын банк 2008 оны дөрөвдүгээр сард 1 америк долларыг 6,99 юаньтай хүчээр тэнцүүлж барьсан билээ. Ингэснээр, юань зах зээлийн бодит ханшнаасаа 40 хувь доогуур үнэлэгдсэн юм. Өмнө нь 2006-2008 онд юаний америк доллартай харьцах ханш 20 хувиар чангарснаас үүдэн ийм бодлого хэрэгжүүлэх болсон хэмээн ажиглагчид онцолдог. Ямартай ч юаний ханш суларсны хүчинд Хятадын бараа бүтээгдэхүүний үнэ хямдарч, олон улсад өрсөлдөх чадвар нь сайжирчээ.

¹МУИС-ийн ОУХС-ийн профессор, доктор/Ph.D/

Гэтэл энэ нь АНУ-д таалагдаагүй юм. Тэд зах зээлийн шударга зарчим алдагдаж байна гэж үзсэн. Үнэн хэрэг дээрээ Хятадтай хийж буй худалдаанд нь их хэмжээний алдагдал гарч буйд дургүйцсэн хэрэг юм. АНУ-ын Засаг захиргаа хямралаас болж туйлдаж гүйцсэн эдийн засгаа сэргээж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх гарц нь экспортод түшиглэх явдал хэмээн үзэж байгаа юм. Тиймээс экспортынхоо өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд Хятадаас юанийн ханшаа чангаруулахыг шаардсан. Хэдийгээр өнгөрсөн оны 6 дугаар сард Хятадын Засгийн газар юанийн ханшийг чөлөөлөхөөр зөвшөөрсөн боловч өнгөрсөн оны сүүл хүртэл америк доллартай харьцах юанийн ханш ердөө 2.6 хувиар чангарсан юм.

Харин Япон Хятадын гишгэсэн мөрөөр алхахаар шийдвэрлэсэн тухайгаа зарлах үед валютын дайн албан ёсоор эхэлсэн гэхэд болно. Японы иений америк доллартай харьцах ханш сүүлийн 15 жилд байгаагүй өндөр түвшин буюу 1 америк доллар 81 иен болж экспортод түшиглэсэн тус орны эдийн засгийг сүйрүүлэх гэж байна. Үүний цаад шалтгаан нь олон жил угжирсан дефляци, Засгийн газрын дотоод өрийн хэмжээ зэрэгтэй холбоотой юм.

Үүнтэй зэрэгцээд Бразил, Мексик, Тайланд, Филиппины Төв банк валютын ханшаа сулруулахыг зорьж эхэлжээ. Энэ нь бусад орнуудын ундуйцлийг төрүүлж, “Бид ч бас чадна” хэмээн дуугарахад хүргэсэн юм. “Валютын дайн” гэж чухамдаа үүнийг л хэлж байна. Экспортод түшиглэсэн орнууд бараа, бүтээгдэхүүнийхээ өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд өртгийг нь бууруулахыг хичээнэ. Ингэхийн тулд олон улсын валют арилжаанд хөндлөнгөөс оролцож, өөрийн мөнгөн тэмдэгтийн өртгийг хямдруулна. Байдал хэвээр үргэлжилбэл цаасан мөнгөний ханш, үнэлэмж буурсаар эцэст нь хэрэглээнээс гаргахад хүргэж ч болно. “Валютын дайн”-ы тухай цуурах болсон энэ үед алтны үнэ тэнгэрт хадаж 1 унц нь 1400 америк доллар руу ойртжээ.

Цаасан мөнгийг үнэгүйдүүлж, дэлхийн эдийн засгийг тогтворгүй болгож байгаа уг үйл явдалд цэг тавихын тулд улс орнууд харилцан буулт хийхээс өөр аргагүй юм. Хятадын хувьд хэдийгээр юанийн ханшийг богино хугацаанд сулруулж чадахгүй гэж байгаа ч АНУ-ын шаардлагыг бусад орнууд дэмжвэл энэ нь тийм ч боломжгүй зүйл биш хэмээн үзэх ажиглагч ч цөөнгүй байна. АНУ-ын Холбооны нөөцийн сангийн Хятадын асуудал эрхэлсэн ахлах зохицуулагч Дэвид Лонвинжер “маш аюултай түвшинд хүрч үнэгүйдээд байгаа юаний ханшийг маш хурдацтай өсгүүлэх талаар бид Хятадыг шахах болно. Хятад улс гадаад валютын зах зээлд юанийхаа ханшийг өсгөхөд хойрго хандсаар байна” гэв. Тэгвэл Хятадын худалдааны сайд Чен Демин сэтгүүлчидтэй уулзах үеэрээ “Сүүлийн гурван жилийн турш Хятадын худалдааны алдагдал тасралтгүй буурч байгаагаас болж барууны орнууд юанийн ханшид ихээхэн анхаарал хандуулж, буруу ойлголт бий болгоод байгаа” гэсэн байна. Сүүлийн үед 14 их наяд америк долларыг хол даваад буй АНУ-ын гадаад өр зөвхөн тус улсын төдийгүй дэлхийн нийтийн хувьд томоохон асуудал болоод байгаа бөгөөд өөрийн асуудлыг даруй шийдвэрлэхгүй бол хямрал ганцхан алхмын цаана байгаа хэмээн эдийн засагчид анхааруулж байгаа билээ. АНУ өрийнхөө дийлэнхийг Хятадаас авсан хэдий ч тус улсын эрх баригчид манай эдийн засаг дэлхийн хамгийн хүчирхэг хэвээр байгаа хэмээн мэдэгдсэн. Дашрамд дурдахад АНУ цэрэг арми болон дайнд дэлхийн бүх орнуудынхыг нийлүүлснээс ч их, Хятадынхаас зургаа дахин их хөрөнгө мөнгө зарцуулсан байна.

“Economic Grid Balance”-ийн ахлах эдийн засагч Николь Раймонд “Хэрвээ одоо л юаний ханшийг хурдацтай өсгөх асуудлаар дорвитой арга хэмжээ авахгүй юм бол энэ нь ноцтой аюул дагуулна. Санхүүгийн хямралын үед юаний ханш хэт доогуур байсан нь улс орнуудын эдийн

засагт маш ноцтой аюул дагуулсан гэдэг нь хожим тодорхой болсон. Юаний ханш хэт доогуур байсан нь хятадуудын зориуд явуулсан арга хэмжээ гэдгийг бид хэт оройтож мэдсэн. Тиймээс хохирол дагуулахаас сэргийлж чадаагүй. Харин одоо ирээдүйд үүсч болох ноцтой эрсдлээс сэргийлэх боломж бидэнд байна” гэж сэтгүүлчдэд ярьжээ. Хятадын Сангийн дэд сайд Зу Гуангиоа” Юаний ханшийг шинэчлэх бодлого дээр АНУ-ын эрх баригчидтай бүрэн санал нийлж байна. Гэхдээ юанийн ханшийг өсгөх хурдцын асуудал дээр өөр байр суурьтай байгаа тул хэлэлцээ хийж асуудлыг эв зүйгээр шийдэх ёстой. Тэгээд ч манай улсын Ерөнхий сайдын орлогч Вани Чишан юанийн бодлогын шинэчлэлийн асуудал бидний ашиг сонирхолд байгаагийн зэрэгцээ энэ асуудлаар маш нухацтай хэлэлцээ явуулах шаардлагатай байгаа талаар Холбооны нөөцийн сангийн ерөнхий нарийн бичгийн дарга Тимоти Жейтнерт хэлсэн” гэж мэдэгдсэн байна.

Түүнчлэн тэрбээр АНУ-ын эрх баригчид эдийн засгийн хамтын ажилагааны тал дээр хатуу байр суурь баримтлахгүй гэж найдаж буйгаа илэрхийлжээ. Зу Гуангиоа цааш өгүүлэхдээ “АНУ-ын эрх баригчид тус улсад хийх бидний хөрөнгө оруулалтын тал дээр хууль ёсны үүднээс хандана гэдэгт итгэж байна. Хамгийн гол нь Хятадын төрийн мэдлийн компаниудад ялгавартай хандахгүй гэдэгт найдаж байгаа. Бид ч Хятадын зах зээлд ажиллахыг хүссэн гаднын компаниудад ялгавартай хандахгүй боломж олгон нээлттэй хандах болно” гэжээ. Дашрамд дурдахад хятадуудын хэрэгжүүлж буй юанийн ханшийн бодлого нь хоёр улсын худалдааны салбарт том нөлөөлөл үзүүлсээр ирсэн. Энэ нь юанийн ханшны сул байдалтай холбоотойгоор өнгөрсөн онд л гэхэд АНУ-ын Хятадтай хийх худалдааны алдагдал 273.1 тэрбум америк доллараас давсан байдлаас харагдаж байна. Энэхүү тооцоо нь АНУ-ын Хятадтай хийх худалдааны алдагдал 2009 оныхоос 20.4 хувиар өссөн болохыг харуулж байгаа юм.

Хятадууд 2010 онд юанийнхаа ханшийг үнэгүйдүүлснээр энэ мэт олон орны худалдааны салбарт ноцтой хохирол учруулсан гэж АНУ-ын эрх баригчид үздэг. Түүнчлэн 2010 онд юанийн ханш дунджаар 30 хувиар үнэгүйдсэн нь Хятадын компаниудад маш том давуу тал болсон гэж үзжээ. Харин эсрэгээрээ гаднын компаниуд үүнээс их хэмжээний алдагдал хүлээсэн байна.

АНУ-ын эрх баригчид юанийн ханшийг илүү хурдацтай өсгүүлэхээр хятадуудыг шахах талаарх мэдээлэл олон нийтэд хүрсний дараа тус валютын ханш дахин унасан. 2011 оны тавдугаар сарын зургааны баасан гаригт америк доллартай харьцах юанийн ханш 0.6 хувиар унаж, нэг америк доллар 6.4959 юаньтай тэнцэж эхэлжээ. Ийнхүү америк долларын эсрэг аажмаар өсч байсан юанийн ханш дахин унасан нь АНУ-ын эрх баригчдын дургүйцлийг хүргэж байгаа нь тодорхой гэж мэргэжилтнүүд үзсэн байна.

АНУ, Хятадын өндөр дээд албаныхан оролцсон стратеги болон эдийн засгийн түншлэлийн уулзалт 2011 оны 5 дугаар сарын 9-10 ны өдрүүдэд Вашингтон хотноо явагдсан. Энэ уулзалтаар АНУ, Хятадын нөлөө бүхий эрхмүүд юанийн ханшны өнөөгийн байдал, инфляци зэрэг олон асуудлаар зөвшилцөлд хүрч чадсан нь хоёр талын яриа хэлэлцээр тун үр дүнтэй болсныг харуулсан. Эл уулзалтад АНУ-ын талаас Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон, Холбооны нөөцийн сангийн тэргүүн Бен Бернанке, Сангийн сайд Тимоти Гайтнер, Хятадын талаас Төв банкны ерөнхийлөгч Зоу Сиочуань, Сангийн дэд сайд Зу Гиангао тэргүүтэй төлөөлөгчид оролцсон байна. Энэ нь Барак Обама, Ху Жинтао нарын уулзалтаас хойш дөрвөн сарын дараа болж буй уулзалт юм. Нэгэнт уулзалт үр дүнтэй болсон тул хоёр талын төлөөлөгчид тус тусын мэдэгдлийг гаргасан байна. Хятадын төлөөлөгчид мэдэгдэлдээ “Бид мөнгөний бодлогоо

хямралын үеийнхээс гаргаж энгийн үеийн статус руу шилжүүлнэ. Түүнчлэн манай улс эдийн засгийн өсөлтөд тохирсон капиталын эрэлтийг хангахыг хичээн ажиллана. Энэ нь мөнгөний ханш үнэгүйдэхээс сэргийлэх болно” гэжээ. Тэдний энэхүү мэдэгдэл америкчуудын талархлыг ихээр хүлээж байна. Учир нь хятадууд өмнө нь амин хувиа хичээсэн мөнгөний уян хатан бус бодлого баримталж байсан юм. Хятадын Засгийн газар 2008 онд юанийн ханшийг ам.доллараас уясан нь АНУ-ын эрх баригчдын дургүйцлийг нэлээд хүргэсэн юм. Харин одооноос тус улсын мөнгөний бодлогод эргэлт гарах магадлал маш өндөр болж байгаа талаар эдийн засагчид мэдэгдэж байна. Одоогоор хятадууд дотоодынхоо зах зээл дэх бараа бүтээгдэхүүний эрэлтийг дэмжихийн зэрэгцээ импортоо нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа талаар энэ улсын төлөөлөгчдийн мэдэгдэлд дурджээ. Энэ нь юанийн ханшийг хурдацтай өсгөхөд амин чухал нөлөөтэй гэж Хятадын эрх баригчид үзжээ. Хятадын төлөөлөгчдийн мэдэгдэлд цааш өгүүлэхдээ “АНУ, Хятадын худалдааны салбар цаашид өргөжин тэлэх боломжтой. АНУ-ын эрх баригчид Хятад руу нийлүүлэх өндөр технологийн бараа бүтээгдэхүүний экспортын хязгаарлагдмал байдлыг алга болгоно гэдэгт итгэж байна. Хэрвээ ингэвэл энэ нь хоёр орны худалдааны салбарын харилцаанд гарах том дэвшил байх болно” гэв.

Хятад улс одоогоор инфляцийг тодорхой түвшинд барихаар шаргуу ажиллаж байна. Гэвч тэдний оролдлого санаснаар болохгүй байгаа.

2011 оны гуравдугаар сард Хятадын инфляци огцом өсч 5.4 хувьд хүрсэн. Энэ нь сүүлийн 32 сарын хугацаан дахь хамгийн өндөр үзүүлэлт байсан нь тус улсын эрх баригчдыг ихэд сандаргажээ. “Economic Balance Deals”-ын ахлах эдийн засагч Жимми Родни “Хятадын инфляци өсч байгаа нь дэлхийн эдийн засгийн өсөлтөд аюул тарьж болзошгүй. Яагаад гэвэл Хятад бол том экспортлогч орон. Тиймээс энэ байдал ноцтой аюул дагуулна. Иймд Хятад болон АНУ-ын Засгийн газар хамтарсан арга хэмжээ авч инфляцийг буулгах хэрэгтэй. АНУ, Хятад хоёр цаашид хамтран ажиллах болсон тул тавдугаар сараас инфляци буурна гэдэгт итгэж байна” гэж мэдэгдэв.

АНУ-ын Сангийн сайд Тимоти Гайтнер уулзалтын дараа хятадуудад ихээхэн найдлага тавьж буйгаа илэрхийлжээ. Тэрбээр мэдэгдэлдээ “Хятад улс юанийхаа ханшийг илүү хурдацтай, өргөн цар хүрээгээр өсгөхийг зөвшөөрнө гэдэгт итгэж байгаа. Бүх гол валютуудтай харьцах юанийн ханш ойрын хугацаанд хурдацтай өснө гэдэгт найдаж байна” гэжээ. АНУ-ын төлөөлөгчдийн мэдэгдэлд ч юанийн ханш өсөх нь дэлхийн эдийн засаг сэргэх үйл явцыг хурдасгахад чухал үүрэгтэйг онцлов.

Хятадын Сангийн дэд сайд Зу Гиангао “АНУ, Хятадын тал юанийн ханш чанга байх ёстой гэдэг дээр бүрэн санал нэгдсэн. Гэхдээ өсгөх үйл ажиллагааг ямар хурдацтай зохион байгуулах вэ? гэдэг дээр хоёр тал өөр байр суурьтай байна. Манай улс юанийн ханшны уян хатан байдлыг нэмэгдүүлэх арилжааны механизмаа шинэчлэх ажлаа үргэлжлүүлнэ. АНУ-ын эрх баригчид юанийнхаа ханшийг илүү хурдацтай өсгөх шаардлагатай гэж үзсээр байгаа” гэж мэдэгдсэн байна. Хятадын талаас Төв банкны ерөнхийлөгч Зоу Сиочуань ч мөн адил юанийн ханшны өсөлтийн хурдац анхаарал татаж байгааг онцолжээ. Сонирхуулахад Хятадын Төв банк юанийн доллартай харьцах ханшийг зориуд доогуур барьж экспортоо нэмэгдүүлэн, худалдааны түншүүдээ санаатайгаар алдагдалд оруулсаар өнөөдрийг хүрсэн. Гэхдээ энэ нь эргээд Хятадын инфляци өсөх гол шалтгаан болсон учир Хятадын тал юанийнхаа ханшийг чөлөөлж шинэчлэлийн бодлого

хэрэгжүүлж эхэлжээ. Хятадын эрх баригчид 2008 оноос эхлэн санхүүгийн салбартаа шинэчлэл хийж эхэлснээс хойш юанийн ханш ердөө зургаан хувиар өссөн байна. Ийм бага хэмжээний өсөлтийг АНУ-ын эрх баригчид хангалтгүй гэж үзэж байгаа юм. Тэд юанийн америк доллартай харьцах ханш дор хаяж 25 хувиар өсч байж хоёр улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлж, Америкийн гадаад худалдааны алдагдал буурна гэж үзэж байгаа юм. Хятадын тал зээлийн хүүгээ нэмэгдүүлж, юанийнхаа ханшийг зах зээлийн зарчмаар чөлөөлөхгүй бол энэ улсын эдийн засаг ноцтой аюултай тулгарна гэж эдийн засагчид үзэж байна.

Нэгэн сонирхолтой баримт хүргэхэд АНУ Хятадад 1.15 их наяд ам.долларын өр, гадаад худалдааны их хэмжээний алдагдалтай тул АНУ-ын эрх баригчид Хятадад тийм ч ширүүн хандаж чадахгүй нь тодорхой гэж шинжээчид үзжээ. Хятадууд инфляция хянаж, импортоо нэмэгдүүлэхийн зэрэгцээ юанийнхаа ханшийг өсгөнө гэж мэдэгдсэний дараа энэхүү валютын ханш бага зэрэг өсчээ. 2011 оны тавдугаар сарын 11-ний лхагва гарагт америк доллартай харьцах юанийн ханш 0.5 хувиар өсч нэг америк доллар 6.4937 юаньтай тэнцжээ. Бусад валютуудтай харьцах юанийн ханш ч энэ өдөр тодорхой хэмжээгээр өссөн байна.